

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Техникийн зохицуулалт батлах тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Автотээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү техникийн зохицуулалтыг 2027 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ҮЕИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Агуулга

- 1) Зорилго, хамрах хүрээ
- 2) Нэр томъёо, тодорхойлолт
- 3) Ангилал, шошго, тэмдэглэгээ, шинж чанар
- 4) Сав баглаа боодол, тэмдэглэгээ, шаардлага
- 5) Аюултай ачаа тээвэрлэх байгууллагад тавигдах шаардлага
- 6) Тээврийн хэрэгсэл болон тоноглолд тавих техникийн шаардлага
- 7) Тээвэрлэлтэд оролцогч талуудын эрх, үүрэг
  - Ачаа илгээгч
  - Тээвэрлэгч
  - Хүлээн авагч
- 8) Тээвэрлэлт
  - Ачааг тээвэрлэлтэд бэлтгэх
  - Ачаа тээвэрлэлтэд бэлтгэх, ачааг хүлээн авах
  - Ачааг аюулгүй ачих, бэхлэх, тээвэрлэх, буулгах, аюулгүй байдлыг хангах
  - Тээвэрлэлтийн тусгай нөхцөл
    - Аюултай ачааг хамт (хольж) тээвэрлэх
    - Хязгаарлагдмал тоо, хэмжээгээр савласан аюултай ачааг тээвэрлэх
    - Чөлөөлөгдсөн тоо, хэмжээгээр савласан аюултай ачааг тээвэрлэх
- 9) Тээвэрлэлтэд тавих хяналт
- 10) Аюул, ослоос урьдчилан сэргийлэх, осол, саатлын үр дагаварыг арилгах
- 11) Боловсон хүчнийг бэлтгэх, түүнд тавигдах шаардлага

# АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

## 1 дүгээр зүйл Зорилго, хамрах хүрээ

- 1.1. Энэхүү техникийн зохицуулалтын зорилго нь автотээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэхэд баримтлах тээвэрлэлтийн аюулгүй байдлын үндсэн шаардлага, техникийн нөхцөлийг тогтооход оршино.
- 1.2. Техникийн зохицуулалтаар дараах үйл ажиллагааг зохицуулна. Үүнд:
  - 1) Аюултай ачаа тээврийн нэр томъёо ба тодорхойлолт;
  - 2) Аюултай ачааны ерөнхий ангилал, жагсаалт;
  - 3) Тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны нөхцөл;
  - 4) Аюултай ачаа тээвэрлэлтэд оролцох ажилтнуудын сургалт;
  - 5) Аюултай ачааны тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангахад хүлээх үүрэг;
  - 6) Аюултай ачаа тээвэрлэлтэд тавих хязгаарлалт болон чөлөөлөлт.
- 1.3. Энэхүү зохицуулалтыг аюултай ачааны тээвэрлэлтэд оролцогч тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, хяналт тавих эрх бүхий албан тушаалтнууд дагаж мөрдөх ба бусад стандарт, хууль тогтоомжийг хамт мөрдөнө. Энэхүү техникийн зохицуулалтад заасан шаардлага нь олон улсын гэрээ, конвенцод зааснаас өөр байх тохиолдолд олон улсын гэрээ, конвенцын заалтыг дагаж мөрдөнө.
- 1.4. Энэхүү техникийн зохицуулалтад тусгагдаагүй нарийвчилсан зохицуулалтыг "Аюултай ачааг авто замаар олон улсад тээвэрлэх тухай Европын хэлэлцээр"-т зааснаар ашиглаж болно.
- 1.5. Энэхүү техникийн зохицуулалт нь дараах нөхцөлд хамаарахгүй. Үүнд:
  - Нийтийн хэрэгцээний болон тусгай зориулалтын авто зам руу гарахгүй зөвхөн үйлдвэрлэлийн хашаан дотор автотээврийн хэрэгслээр хийгдэх аюултай ачааны тээвэрлэлтэд;
  - Зэвсэг хүчний техник хэрэгслээр хийгдэж буй цэрэг дайны зориулалттай аюултай ачааны тээвэрлэлтэд;
  - Энэхүү техникийн зохицуулалтад болон бусад хууль тогтоомжид заасан бага хэмжээгээр тээвэрлэж буй зарим аюултай ачааны тээвэрлэлтэд.
- 1.6. Энэхүү техникийн зохицуулалтад тусгагдаагүй асуудлаар тодорхой төрлийн аюултай ачааг тээвэрлэх чиглэлээр тухайн асуудлыг хариуцсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаас нарийвчилсан дүрэм, журмыг баталсан бол тэдгээрийг мөрдөнө.

## **2 дугаар зүйл**

### **Нэр томъёо ба тодорхойлолт**

Энэхүү техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1) **“Аюултай ачаа”** гэж автотээврийн хэрэгслээр тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул хохирол учруулах химийн хортой болон аюултай бодис, аюултай хог хаягдал, тэдгээрийн ариутгаагүй сав, баглаа боодлыг;
- 2) **“НҮБ-ын дугаар (UN number)”** гэж нь аюултай бодис, эд зүйлсийг олон улсын хэмжээнд таньж тогтооход ашигладаг дөрвөн оронтой тоог;
- 3) **“Дөл авалцах температур”** гэдэг нь шингэний уур агаартай холилдсоноор хялбар шатах холимог үүсгэх хамгийн бага температурыг.
- 4) Энэ техникийн зохицуулалтад дурдсан аюултай бодисын тодорхойлолт, нэр томъёог Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан аргачлалд дурдсаны дагуу ойлгоно.

## **3 дугаар зүйл**

### **Аюултай ачааны ангилал, дэд ангилал**

3.1. Ачааг аюулын зэргээс хамаарч дараах ангилалд хуваана. Үүнд:

- 1 дүгээр ангилал – Тэсэрч дэлбэрэх бодис, бүтээгдэхүүн;
- 2 дугаар ангилал – Хийнүүд;
- 3 дугаар ангилал – Шатамхай шингэнүүд;
- 4 дүгээр ангилал - шатамхай хатуу бодис;
- 5 дугаар ангилал – Хүчиллэг, исэлдүүлэгч бодис болон органик пероксидууд;
- 6 дугаар ангилал – Хортой болон халдварт бодисууд;
- 7 дугаар ангилал – Цацраг идэвхт бодисууд;
- 8 дугаар ангилал – Идэмхий бодисууд;
- 9 дүгээр ангилал – Бусад аюултай бодисууд.

Хэрэв тухайн бодис, уусмал эсвэл холимог нь өөрийн аюултай шинж чанараараа нэгээс олон ангилал, эсвэл нэгээс олон бүлэгт хамаарахаар байвал хамгийн аюултайгаас нь бага аюултай руу эрэмбэлэх ачаа тээвэрлэлтийн дараалал (тэргүүлэх чиглэл) нь дараах байдалтай байна: Ангилал 7, 1, 2, 3 (Шингэн төлөвтэй, мэдрэг чанарыг нь бууруулсан тэсрэх бодисууд), 4.1, 4.2, 5.2, 6.1 (сав баглаа боодлын I дүгээр бүлгийн хорт бодисууд) эсвэл 8 (хортой бодисууд), 6.2.

**3.2. Аюултай ачааны шинж чанар, дэд ангилал**

**3.2.1 Аюулын 1 дүгээр ангилалд хамаарах ачааны шинж чанар**

Өөрийн шинж чанараараа тэсэрч дэлбэрэх, тэсрэлтийн нөлөө бүхий гал түймэр үүсгэх чадвартай тэсэрч дэлбэрэх материалууд, мөн тэсрэх бодис агуулсан төхөөрөмжүүд болон пиротехникийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулагдсан тэсрэх бодисууд.

**Дэд ангилал 1.1.** – Түргэн хугацаанд гал авалцан бүх ачааг хамарч бөөнөөр хүчтэй дэлбэрэх аюултай пиротехникийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс хамаарна.

**Дэд ангилал 1.2.** – Галын улмаас бөөнөөр бус хэсэгчилсэн дэлбэрэлт үүсгэх аюултай пиротехникийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс;

**Дэд ангилал 1.3.** – Галын улмаас бага хэмжээний дэлбэрэлт үүсгэх шинж чанартай пиротехникийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс хамаарна.

Дэд ангилал “1.1”, “1.2”, “1.3”-ын шошгоны тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улбар шар
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифрийн өнгө: хар

Дээд талд: дэлбэрч байгаа бөмбөг

Доод талд:

\*\* - дэд ангиллыг тэмдэглэгээлэх хэсэг. Цифрийн өндөр – 15 мм.

\* - Тохирох бүлгийн тэмдэглэгээлэгээг хийх хэсэг. Үсгийн өндөр – 15 мм, доод өнцөгт 10 мм-ийн өндөртэй 1 гэсэн цифр бичнэ.

**Дэд ангилал 1.4.** – Галын улмаас дэлбэрэх эрсдэл багатай пиротехникийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс хамаарна.

Дэд ангилал 1.4-ийн шошго, тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улбар шар
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифрийн өнгө: хар
- Дээд тал – 1.4. гэсэн цифрийн өндөр – 300мм, цифрийн зураасны өргөн – 5 мм.
- Доод тал: \* - Тохирох бүлгийн тэмдэглэгээлэгээг хийх хэсэг. Үсгийн өндөр – 20 мм, доод өнцөгт 10 мм-ийн өндөртэй 1 гэсэн цифр бичнэ.

**Дэд ангилал 1.5.** – Тээвэрлэлтийн явцад шаталтаас тэсрэлтэд шилжих магадлал багатай, галд хэт мэдрэмтгий биш боловч бөөнөөр тэсэрч дэлбэрэх аюултай тэсрэх бодис хамаарна.

Дэд ангилал “1.5”-ийн шошго, тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улбар шар
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифрийн өнгө: хар
- Дээд хэсэгт: 1.5. гэсэн цифрийн өндөр – 30 мм, цифрийн зураасны өргөн – 5 мм.
- Доод хэсэгт: D - Тохирох бүлгийн тэмдэглэгээлэгээ. Үсгийн өндөр – 20 мм, доод өнцөгт 10 мм-ийн өндөртэй 1 гэсэн цифр бичнэ.

**Дэд ангилал 1.6.** – Галд хэт мэдрэмтгий бус, бөөнөөр тэсэрч дэлбэрдэггүй, санамсаргүй байдлаар галаар өдөөгдөх магадлал багатай тэсрэх бодис агуулсан эд зүйлс хамаарна.

Дэд ангилал “1.6”-ын шошго, тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улбар шар
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифрийн өнгө: хар
- Дээд хэсэгт: “1.6” тооны өндөр – 30 мм, цифрийн зураасны өргөн – 5 мм.
- Доод хэсэгт: N - Тохирох бүлгийн тэмдэглэгээлэгээ. Үсгийн өндөр – 20 мм, доод өнцөгт 10 мм-ийн өндөртэй 1 гэсэн цифр бичнэ.

### **3.2.2 Аюулын 2 дугаар ангилалд хамаарах ачааны шинж чанар**

Дулааны +20<sup>0</sup> С-ийн температурт савны доторх даралт 1х10<sup>5</sup> Па (кг/см<sup>3</sup>)-тай тэнцүү буюу их, дулааны +50<sup>0</sup> С-ийн температурт уурын туйлын даралт 1х10<sup>5</sup> Па (кг/см<sup>3</sup>)-тэй тэнцүү буюу их, хямарлын температур +500 С-ээс бага байх гэсэн нөхцөлүүдийн аль нэг шинжийг хангасан хий болон шингэн бодис.

**Дэд ангилал 2.1.** – Шатамхай хий.

Дэд ангилал “2.1”-ийн шошго, тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улаан
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: хар
- Дээд хэсэгт: Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт: Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.




Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улаан
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Цагаан.
- Дээд хэсэгт: Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт: Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 2.2.** – Шатамхай бус хоргүй хий.

Дэд ангилал “2.2”-ын шошго, тэмдэглэгээний загвар:




Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Ногоон.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт: Хийн баллон.
- Доод хэсэгт: Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Ногоон.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Цагаан.
- Дээд талд - Хийн баллон.
- Доод талд - Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Ногоон.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт: Хийн баллон.
- Доод хэсэгт: Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Ногоон.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Цагаан.
- Дээд талд - Хийн баллон.
- Доод талд - Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 2.3.** – Хортой хий.

Дэд ангилал “2.3”-ын шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Хэмжээ: 100 мм х 100 мм
  - Дэвсгэрийн өнгө: Цагаан.
  - Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Цагаан.
  - Дээд хэсэгт: Гавлын яс, зөрүүлсэн яс.
  - Доод хэсэгт: Доод өнцөгт цифр 2, цифрийн өндөр – 10 мм.
- Дэд ангилал 2.4. – Түргэн шатамхай хий;
  - Дэд ангилал 2.5. – Химийн тогтворгүй хий;
  - Дэд ангилал 2.6. – Химийн тогтворгүй хортой хий.

Хий аюулын шинж чанараасаа хамаарч дараах бүлэгт хуваагдана. Үүнд:

- ✓ **A** – амьсгал боогдуулах;
- ✓ **O** – Исэлдүүлэгч;

- ✓ **F** - Түргэн шатамхай;
- ✓ **T** - Хортой;
- ✓ **TF** - Хортой, шатамхай;
- ✓ **TC** – Хортой, зэврүүлэгч;
- ✓ **TO** – Хортой, исэлдүүлэгч;
- ✓ **TFC** – Хортой, шатамхай, зэврүүлэгч;
- ✓ **TOC** – Хортой, исэлдүүлэгч, зэврүүлэгч.

### 3.2.3. Аюулын 3 дугаар ангилалд хамаарах ачааны шинж чанар

Битүү сав (тигл буюу лабораторт ашигладаг битүү шил)-д дулааны  $+61^{\circ}\text{C}$  болон түүнээс бага температурт, задгай саванд дулааны  $+66^{\circ}\text{C}$ -ээс бага температурт гал авалцах шинж чанартай шингэн, шингэний холимог, уусмал.

**Дэд ангилал 3.1.** – Хаалттай сав (тигл)-д  $-18^{\circ}\text{C}$ -ээс доош температурт, эсвэл бусад амархан шатах шинж чанараас бусад аюултай шинж чанартай бодистой нийлж авалцах боломжтой, бага авалцах температур шатамхай шингэн бодисууд хамаарна.

**Дэд ангилал 3.2.** - Хаалттай сав (тигл) дахь авалцах температур нь  $-18^{\circ}\text{C}$ -  $23^{\circ}\text{C}$ , дундаж авалцах температуртай шатамхай шингэн бодисууд хамаарна.

Дэд ангилал “3.1 болон 3.2”-ын шошгоны тэмдэглэгээ:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улаан.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт - Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт - Доод өнцөгт цифр 3, цифрийн өндөр – 10 мм.



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Улаан.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Цагаан.
- Дээд хэсэгт - Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт - Доод өнцөгт цифр 3, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 3.3.** - Хаалттай сав (тигл)-д авалцах температур нь -230 С- 610 С, өндөр авалцах температуртай шатамхай шингэн бодисууд хамаарна.

**3.2.4. Аюулын 4 дүгээр ангилалд хамаарах ачааны шинж чанар**

Тээвэрлэлтийн явцад гаднах дулааны нөлөөнөөс, үрэлтээс, чийгнээс болон дангаараа химийн урвалд орсноос гал авалцах хатуу бодис, бүтээгдэхүүн.

**Дэд ангилал 4.1.** – Гаднах галын эх үүсвэрийн (оч, дөл эсвэл үрэлт) богино хугацааны нөлөөллөөр амархан авалцах, идэвхтэй шатах чадвартай хатуу бодис хамаарна.

Дэд ангилал “4.1”-ийн шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Ижил зайтай долоон босоо улаан судалтай цагаан.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Хөндлөн зураасны дээр галын дөл.

- Доод хэсэгт – Доод өнцөгт цифр 4, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 4.2.** - Тээвэрлэлтийн ердийн нөхцөлд өөрөө аяндаа халах, авалцах (гал гарах) боломжтой бодисууд хамаарна.

Дэд ангилал “4.2”-ын шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Дээд тал нь цагаан, доод нь тал улаан.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, тоо, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт – Доод өнцөгт “4”-ийн тоо, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 4.3.** - Устай харилцан үйлчлэх үедээ шатамхай хий ялгаруулдаг бодисууд хамаарна.

Дэд ангилал “4.3”-ын шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Хөх, эсхүл цэнхэр.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Хөндлөн зураасны дээр галын дөл.
- Доод хэсэгт – Доод өнцөгт “4”-ийн тоо, цифрийн өндөр – 10 мм.

**3.2.5. Аюулын 5 дугаар ангилалд хамаарах ачааны шинж чанар**

Хүчилтөрөгч ялгаруулдаг, шаталтыг дэмждэг, түүнчлэн зарим нөхцөлд бусад бодистой нийлж шаталт, дэлбэрэлт үүсгэдэг исэлдүүлэгч бодисууд болон органик хэт исэл (пероксид)

**Дэд ангилал 5.1.** – Хүчилтөрөгч ялагруулж, шаталтын эрчмийг нэмэгдүүлдэг исэлдүүлэгч бодисууд хамаарна.

Дэд ангилал 5.1.-ийн шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Шар.
- Аюулын тэмдэглэгээлэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Дугуй дүрсний дээр галын дөл.
- Доод хэсэгт – Доод өнцөгт “5.1”-ийн тоо, тооны өндөр – 10 мм.

**Дэд ангилал 5.2.** – Ихэнх тохиолдолд шатамхай, исэлдүүлэгч бодис ижил нөлөө үзүүлдэг болон бусад бодистой урвалд ордог органик хэт ислүүд. Тэдгээрийн дийлэнх нь амархан шатдаг, цохилт болон үрэлтэд тэсвэргүй байдаг.

Дэд ангилал 5.2.-ын шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Дэд тал нь улаан, доот тал нь шар.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.

- Дээд хэсэгт – Дугуй дүрсний дээр галын дөл.
- Доод хэсэгт – Доод өнцөгт цифр 5.2, цифрийн өндөр – 10 мм.

### 3.2.6. Аюулын 6 дугаар ангилалд хамаарах бодисын шинж чанар

Залгих, амьсгалах, эсхүл арьсаар болон салст хэсгээр хүрсэн тохиолдолд үхэлд хүргэх, хордуулах, өчлөлүүлэх чадвартай хортой болон халдварт бодисууд.

**Дэд ангилал 6.1.** – Амьсгал, залгих, арьс, салстаар хүрэх тохиолдолд хордлого үүсгэх чадвартай хортой бодисууд хамаарна.

Дэд ангилал “6.1”-ийн шошго, тэмдэглэгээний загвар:



#### Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Цагаан.
- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Гавлын яс, зөрүүлсэн яс.
- Доод хэсэгт – Доод өнцөгт цифр 6, цифрийн өндөр – 10 мм.

**Дэд ангилал 6.2.** – Хүн, амьтанд өвчин үүсгэдэг бичил биет бодис болон материалууд.

Дэд ангилал “6.2”-ын шошго, тэмдэглэгээний загвар:



#### Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэрийн өнгө: Цагаан.

- Аюулын тэмдэглэгээ, үсэг, цифр, зураасны өнгө: Хар.
- Дээд хэсэгт – Тойрог дээр давхарласан гурван хугархай хавирган сар.
- Доод хэсэгт – Доод өнцөгт цифр 6, цифрийн өндөр – 10 мм.

### 3.2.7. Аюулын 7 дугаар ангилал

Цацрагийн идэвхийн хувийн түвшин нь 70 кБк/кг (2нКи/г)-аас дээш цацраг идэвхт бодисууд хамаарна.

#### 7 дугаар ангиллын I дүгээр зэрэглэлийн аюултай ачааны шошго, тэмдэглэгээ



- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Өнгө: Бүхэлдээ цагаан дэвсгэртэй.
- Хэмжээ: 100 мм x 100 мм
- Тэмдэглэгээ: Дээд хэсэгтээ хар өнгөөр зурсан "Гурван навчит" (Trefoil) буюу цацраг идэвхт бодисын олон улсын таних тэмдэглэгээтэй. доод хэсэгт "RADIOACTIVE" гэсэн бичиг байх ба түүний ард нэг улаан босоо зураас I зэрэглэлийг илтгэнэ. Зураасны өндөр 10 мм.
- "CONTENTS" (саван дахь бодисын агууламж), "ACTIVITY" (цацрагийн идэвх) бичиг байна. Үсгийн өндөр 5 мм.
- Тээврийн индекс (TI)-ийг бичнэ.
- Дугаар: Доод буланд "7" гэсэн ангиллын дугаар байрлана. Цифрийн өндөр 10 мм.

Жич: Тээвэрлэлтийн индекс (Transport Index) нь 7 дугаар ангиллын ачааны баглаа боодол эсвэл контейнерын гадаргуугаас гарч буй цацрагийн түвшинг хянах, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашигладаг тоон үзүүлэлт бөгөөд тээвэрлэлтийн индекс нь Засгийн газрын 2019 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Цацраг идэвхт бодис аюулгүй тээвэрлэх дүрэм"-д зааснаас хэтрэхгүй байна.

#### 7 дугаар ангиллын II дугаар зэрэглэлийн аюултай ачааны тэмдэглэгээ



- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ – 100 мм x 100 мм
- Өнгө: Дээд тал шар, доод тал цагаан дэвсгэртэй.
- Тэмдэглэгээ: Дээд хэсэгтээ хар өнгөөр зурсан "Гурван навчит" (Trefoil) буюу цацраг идэвхт бодисын олон улсын таних тэмдэглэгээтэй.
- Бичиг: Төв хэсэгт нь "RADIOACTIVE" гэсэн бичиг байх ба түүний ард хоёр улаан босоо зураас II зэрэглэлийг илтгэнэ. Зураасны өндөр 10 мм.
- "CONTENTS" (саван дахь бодисын агууламж), "ACTIVITY" (цацрагийн идэвх) бичиг байна. Үсгийн өндөр 5 мм.
- Тээврийн индэкс (TI)-ийг бичнэ.
- Дугаар: Доод буланд "7" гэсэн ангиллын дугаар байрлана. Цифрийн өндөр 10 мм.

### **7 дугаар ангиллын III дугаар зэрэглэлийн аюултай ачааны тэмдэглэгээ:**



- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ – 100 мм x 100 мм
- Өнгө: Дээд тал шар, доод тал цагаан дэвсгэртэй.
- Тэмдэглэгээ: Дээд хэсэгтээ хар өнгөөр зурсан "Гурван навчит" (Trefoil) буюу цацраг идэвхт бодисын олон улсын таних тэмдэглэгээтэй.
- Бичиг: Төв хэсэгт нь "RADIOACTIVE" гэсэн бичиг байх ба түүний ард гурван улаан босоо зураас III зэрэглэлийг илтгэнэ.

- "CONTENTS" (саванд байгаа бодисын агууламж), "ACTIVITY" (цацрагийн идэвх) бичиг байна. Үсгийн өндөр 5 мм.
- Тээврийн индекс (TI)-ийг бичнэ.
- Дугаар: Доод буланд "7" гэсэн ангиллын дугаар байрлана. Цифрийн өндөр 10 мм.

**7 дугаар ангиллын хуваагдач (цөмийн гинжин урвалд орох чадвартай, онцгой аюултай цацраг идэвхт бодис) ачааны аюулын тэмдэглэгээ**



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм x 100 мм
- Дэвсгэр өнгө: Бүхэлдээ цагаан.
- Бичиг: Дээд хэсэгт хар өнгөөр "FISSILE" гэж том үсгээр бичсэн байна. Үсгийн өндөр 7 мм. Доод хэсэгт Хар хүрээтэй тэгш өнцөгт дотор "CRITICALITY SAFETY INDEX" (Критик аюулгүй байдлын индекс) гэсэн бичигтэй. Үсгийн өндөр 7 мм.
- Дугаар: Хамгийн доод буланд ангиллын дугаар болох "7" тоо бичнэ. Тооны өндөр 10 мм.

### **3.2.8. Аюулын 8 дугаар ангилал**

Нүд болон амьсгалын замын эрхтнийн салстыг гэмтээдэг, төмөр болон тээврийн хэрэгсэл, ачааг зэврүүлэх, мөн органик бодисууд болон зарим химийн бодистой урвалд орж гал авалцах чадвартай идэмхий болон зэврүүлэгч бодисууд.

**Дэд ангилал 8.1.** – Хүчлүүд

**Дэд ангилал 8.2.** – Шүлтүүд;

**Дэд ангилал 8.3.** - Төрөл бүрийн идэмхий болон зэврүүлэгч бодисууд.

8 дугаар ангиллын аюултай ачааны шошго, тэмдэглэгээний загвар:



Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм x 100 мм
- Дэвсгэр өнгө: Дээд хэсэг цагаан, доод хэсэг цагаан хүрээтэй хар.
- Аюулын дүрс: Хоёр хуруу шилэнд байгаа шингэн нь металл болон хүний гар дээр асгарч, идэж байгааг дүрсэлсэн аюулын тэмдэглэгээ.
- Дугаар: Хамгийн доод буланд ангиллын дугаар болох "8" тоо бичнэ. Тооны өндөр 10 мм.


**3.2.9. Аюулын 9 дүгээр ангилал**

Өмнө нь дурдсан ангиллаас ялгаатай боловч хадгалалт тээвэрлэлтийн явцад аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөж гүйцэтгэх шаардлагатай бусад бодисууд.

**Дэд ангилал 9.1.** – Шинж чанараараа 3 болон 4 дүгээр ангилалд ордоггүй, гэхдээ тодорхой нөхцөлд галын аюултай байдал үүсгэдэг (Битүү саванд  $+61^{\circ}\text{C}$ -ээс  $100^{\circ}\text{C}$ -ийн дулаанд гал авалцах шатамхай шингэн болон тэдгээртэй ижил материалууд) шингэн болон хатуу бодисууд хамаарна.

**Дэд ангилал 9.2.** – Тодорхой нөхцөлд идэмхий болон зэврүүлэгч бодис болдог шинж чанартай бодисууд.

**9 дүгээр ангиллын аюултай ачааны аюулын талаарх шошгоны тэмдэг, тэмдэглэгээ:**



### Тэмдэглэгээний тайлбар:

- Дүрс: Орой дээрээ байрласан квадрат (ромбо) хэлбэртэй.
- Хэмжээ: 100 мм х 100 мм
- Дэвсгэр өнгө: Дээд хэсэг цагаан, доод хэсэг цагаан хүрээтэй хар. Босоо шугам болон тоо хар.
- Аюулын дүрс: Ижил зайтай 7 босоо шугам.
- Дугаар: Хамгийн доод буланд ангиллын дугаар болох доогуур зураастай "9" тоо бичнэ. Тооны өндөр 10 мм.

3.3. 1 дүгээр ангилалын аюултай ачаа (Тэсэрч дэлбэрэх бодис болон бүтээгдэхүүнүүд)-д дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Химийн урвалд маш хурдацтайгаар орж, хий ялгаруулан дулааны их температур болон өндөр даралтын нөлөөгөөр ойр орчмын биетийг гэмтээх чадвартай хатуу, шингэн болон холимог бодис, бүтээгдэхүүн. Ийм төрлийн аюултай бодисонд дарьны бүтээгдэхүүн, дарь, тринитротолуол, динамит гэх мэт хамаарна;
- Тэсрэлт үүсгэхгүйгээр өөрөө явагдах дулаан ялгаруулах химийн урвалын дүнд дулаан, гэрэл, дуу чимээ, хий болон утаа гаргах зориулалттай пиротехникийн бодис эсвэл тэдгээрийн холимог;
- Нэг болон түүнээс дээш төрлийн тэсрэх бодис эсвэл пиротехникийн бодисоос бүрдсэн тэсэрч дэлбэрэх хэрэгсэл;
- Тэсэлгээний ажил хийх болон пиротехникийн эффект үзүүлэх зориулалтаар үйлдвэрлэгдсэн дээр дурдагдаагүй бусад бодис болон эд зүйлс.

3.4. 2 дугаар ангиллын аюултай ачаа (Хий)-нд дараах зүйлс хамаарна. Үүнд:

2 дугаар ангиллын ачаанд цэвэр хий, нэг болон хэд хэдэн хийний холимог,

## 4 дүгээр зүйл

### Техникийн шаардлага

#### 4.1. Сав баглаа, боодолд тавих шаардлага

4.1.1. Аюултай ачааны сав баглаа, боодол нь үйлдвэрлэгчээс тогтоосон шаардлагыг хангахуйц, холбогдох стандартын шаардлагыг хангасан байна. Аюултай ачааны савлагааны бүлэг (Packing Group) нь тухайн бодисын аюулын зэрэглэлээс хамаарч гурван үндсэн хэсэгт хуваагддаг. Үүнд:

- **I бүлэг (Packing Group I):** Маш их аюултай бодисууд. Хамгийн өндөр зэрэглэлийн бат бөх савлагаа шаардана.
- **II бүлэг (Packing Group II):** Дунд зэргийн аюултай бодисууд.
- **III бүлэг (Packing Group III):** Бага зэргийн аюултай бодисууд. Хамгийн бага шаардлага бүхий савлагааг ашиглаж болно.

4.1.2. Сав баглаа боодол болон жийргэвч материалын төрлийг тухайн ачааны онцлог шинж чанарт тохируулан сонгох бөгөөд тухайн ачаатай ямар нэгэн

байдлаар урвалд ордоггүй, эсвэл урвалд орохоос хамгаалсан бүрхүүлтэй байна.

- 4.1.3. Хуванцар материалаар хийгдсэн сав баглаа боодлын материал нь аюултай бодисыг нэвтрүүлдэггүй, температурын нөлөө болон ашиглалтын явцад зөөлөрч бат бэх чанараа алдахгүй байх шаардлагатай.
- 4.1.4. Атираат болон бусад төрлийн цаасан хайрцууд нь хангалттай бат бөх, усны хамгаалалттай (чийгтсэн үед механик бат бөх чанараа хадгалдаг) байх бөгөөд ашиглаж байсан хуучин цаасан хайрцагт аюултай ачаа тээвэрлэхийг хориглоно.
- 4.1.5. Шилэн сав нь нягт таглаатай байх бөгөөд бат бөх хайрцаг, модон жааз эсвэл сагсанд байрлуулж, хоорондох зайг урвалд ордоггүй жийргэвч болон шингээгч материалаар дүүргэсэн байна. Шилэг савны хүзүү нь сагс эсвэл жаазны ирмэгээс илүү гарсан байж болохгүй.
- 4.1.6. Битүүмжтэй байх металл сав баглаа боодол нь гагнагдсан эсвэл жийргэвч болон эрэгддэг бөглөөтэй байх шаардлагатай бөгөөд тэдгээрт хийсэн туршилтын даралтын хэмжээ болон хамгийн сүүлд баталгаажуулалт хийсэн огноог заасан бичиглэлийг байрлуулна.
- 4.1.7. Өндөр даралтат хийх болон шингэн тээвэрлэх зориулалттай баллонууд нь холбогдох стандарт, дүрэм журмын шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- 4.1.8. Шингэн тээвэрлэх савнуудыг бүрэн дүүргэж болохгүй бөгөөд тээвэрлэж буй шингэний дүүргэлт нь нийт багтаамжийн 90%-тай тэнцүү байна (аммиакын усан уусмал болон шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хийн хувьд 85%).
- 4.1.9. Аюулын тэмдэглэгээг дараах байдлаар байршуулна. Үүнд:
- Тэгш өнцөгт параллелепипед хэлбэртэй сав баглаа боодол (тэр дундаа чингэлэг)-ны хажуу тал, нүүрэн тал болон дээд талд;
  - Торхон дээр нэг ёроол (орой) болон их биений (бүрхүүл) хоёр эсрэг талд;
  - Шуудайн дээр дээд хэсгийн оёдол орчимд хоёр талд;
  - Боодол болон бөөн ачаан дээр — нүүрэн тал болон хажуугийн гадаргуу дээр;
  - Бусад төрлийн сав баглаа боодолд аль болох ил харагдахуйц, эвтэйхэн байрлалд.
- 4.1.10. Аюултай ачаатай харьцах (арчилгааны) тэмдэглэгээг аюулын ангиллын дараа хийнэ.
- 4.1.11. Хэрэв ачаа нь нэгээс олон төрлийн аюулын шинж чанартай бол тухайн аюулын бүх төрлүүдийг заасан аюултай ачааны тэмдгийг сав баглаа боодол дээр байрлуулна. Ангиллын дугаарыг үндсэн аюулын төрлийг заасан тэмдэг дээр бичнэ.
- 4.2. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд тавих шаардлага.**

- 4.2.1. Аюултай ачааг зөвхөн зориулалтын, эсхүл үйлдвэрийн нөхцөлд тусгайлан тоногосон тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх, турших, хүлээн авах, ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлд нэмэлт тоноглол суурилуулах ажлыг техникийн даалгавар, техникийн нөхцөлийн дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж хийж гүйцэтгэнэ.
- 4.2.2. Тэсэрч дэлбэрэх болон амархан гал авалцах бодис тээвэрлэлтэд тогтмол ашиглагддаг автомашинуудын яндангийн гаралтын хоолойг радиаторын өмнө тал руу налуулан гаргаж тоногосон байх ёстой. Хэрэв хөдөлгүүрийн байрлалаас шалтгаалан ийм өөрчлөлт хийх боломжгүй бол яндангийн хоолойг кузов буюу цистерн болон түлшний шугамаас гадагш, баруун гар тал руу гаргаж болно.
- 4.2.3. Тээврийн хэрэгслийн шатахууны сав нь аккумулятораас хол байрлах, эсвэл түүнээс үл нэвтрэх тусгаарлагчаар тусгаарлагдсан байх шаардлагатай. Мөн хөдөлгүүр, цахилгааны утас болон яндангийн хоолойноос хол байх бөгөөд хэрэв шатахуун гоожсон тохиолдолд тээвэрлэж буй ачаанд хүрэхгүйгээр шууд газарт асгарахаар байрласан байна. Түлшний сав нь ёроол болон хажуу талуудаараа хамгаалалтын гэр (хуяг)-тэй байна.
- 4.2.4. 1, 2, 3, 4 болон 5 дугаар ангиллын аюултай ачааг нэг тээвэрлэх автомашин тохиолдолд яндангийн гаралтын хэсэгт оч баригч тор суурилуулж болно.
- 4.2.5. 1, 2, 3, 4 болон 5 дугаар ангиллын аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн цахилгаан тоноглол нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- Шугамын хүчдэл нь 25 Вольт-оос хэтрэхгүй;
  - Цахилгаан дамжуулах утаснууд нь зэврэлтэд тэсвэртэй, заадасгүй бүрхүүлээр хамгаалагдсан байх бөгөөд утас халахаас бүрэн сэргийлэхээр тооцоологдсон байх;
  - Цахилгаан сүлжээг хэт ачааллаас хамгаалах (үйлдвэрийн аргаар хийгдсэн) хайламтгай гал хамгаалагч эсвэл автомат салгууртай байх;
  - Цахилгааны утаснууд нь найдвартай тусгаарлагчтай, бат бөх бэхлэгдсэн байх ёстой бөгөөд автомашины эд ангиудад цохигдох, үрэгдэхээс хамгаалагдсан, мөн хөргөлтийн систем болон яндангийн утаа зайлуулах системээс ялгарах халуунаас тусгаарлагдсан байрлалд байх;
  - Хэрэв аккумуляторууд хөдөлгүүрийн капот доор байрлаагүй бол тэдгээрийг дотор хана нь тусгаарлагдсан, металл эсвэл түүнтэй дүйцэхүйц бат бөх материалаар хийгдсэн, агааржуулалттай хайрцаг(тасалгаан)-т байрлуулна;
  - Эрээстэй суурь бүхий чийдэн ашиглахыг хориглоно. Тээврийн хэрэгслийн бүхээгт ил цахилгаан утас байх ёсгүй бөгөөд доторх гэрэлтүүлгийн чийдэнгүүд нь бат бөх хамгаалалтын тор эсвэл сараалжтай байна;
  - Аюултай ачаа тээвэрлэж буй автомашин нь зогсож байх үед 200 мм-ээс багагүй урттай хэсгээрээ газарт хүрч байх металл

газардуулгын гинж болон статик, агаар мандлын цахилгаан цэнэгээс хамгаалах метал газардуулагч гадасаар тоноглогдсон байна;


- Фургон төрлийн бүхээгтэй автомашины бүхээг нь бүрэн битүүмжлэгдсэн, бат бөх, ямар нэгэн нүх завсаргүй байх ёстой бөгөөд тээвэрлэж буй аюултай ачааны шинж чанараас хамааран агааржуулалтын системээр тоноглогдсон байна. Дотор доторлогоонд оч үүсгэдэггүй материал ашиглах ба модон материалууд нь галд тэсвэртэй бодисоор нэвчүүлсэн (тусгай түрхлэгтэй) байх ёстой. Хаалганууд нь цоожтой байна;
- Тээврийн хэрэгслийн цистерний арын хэсэгт түүний нийт өргөнтэй тэнцүү мөргөлтөөс хангалттай хамгаалах бампераар тоноглогдсон байх ёстой. Цистерний арын хана болон бамперын арын хэсэг хоорондын зай 100 мм-ээс багагүй байна (энэ зайг цистерний ханын хамгийн арын цэг эсвэл тээвэрлэж буй бодистой хүрэлцэж буй цухуйсан арматур холбох хэрэгслээс тооцож хэмжинэ);
- Цистерний дээд хэсэгт байрлах хоолой болон туслах тоноглолууд нь автомашин онхолдох үед эвдрэл гэмтлээс хамгаалагдсан байх ёстой. Ийм төрлийн хамгаалалтын бүтцийг хүчитгэсэн цагираг, хамгаалалтын малгай (бүрхүүл), хөндлөн болон тууш эд анги хэлбэрээр хийж болох бөгөөд тэдгээрийн хэлбэр хийц нь үр ашигтай хамгаалалтыг хангахуйц байна;

4.2.6. Аюултай ачаа тээвэрлэхэд зориулагдсан автомашин нь дараах бүрэн ажиллагаатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн осол, саатлын үеийн засвар үйлчилгээнд зориулсан гар багаж, хэрэгслийн иж бүрдэл;
- Энэхүү техникийн зохицуулалтын 6.1.8, 6.1.9-д заасан гал унтраагуур, хүрз болон гал унтраахад хүрэлцэхүйц хэмжээний элсний нөөц;
- Тээврийн хэрэгсэл бүрт тухайн тээврийн хэрэгслийн төрөл болон дугуйны диаметрт тохирсон нэгээс цөөнгүй ивүүр байна;
- Өөрийн тэжээлийн эх үүсвэрээс ажилладаг улбар шар өнгийн анивчдаг (эсвэл тогтмол) хоёр гар чийдэн (гэрэл)-тэй байна. Эдгээр нь тээвэрлэж буй ачааг шатаах, гал гаргах эрсдэлгүй байхаар хийгдсэн байх шаардлагатай;
- Хэрэв тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэг эвдрэлтэй бол шөнийн цагт, эсвэл үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд зогсолт хийхдээ зам дээр улбар шар өнгийн гар чийдэн (гэрэл)-г тээврийн хэрэгслийн урд болон хойд талд 10 м-ээс багагүй зайд байрлуулах шаардлагатай;
- Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл болон тээвэрлэж буй аюултай бодисыг саармагжуулах бодис, хэрэгсэл;
- Газарт байрлуулах боломжтой суурьтай анхааруулах тэмдэг;
- Нүдний хамгаалалтын хэрэгсэл (нүдний шил), нүд угаах шингэн;

- Ослын хантааж, хамгаалалтын бэлий, амны хаалт;
- 4.2.7. Тээврийн хэрэгсэл бүрт тээврийн хэрэгслийн хөдөлгүүр болон жолоочийн бүхээгт гарсан галыг унтраахад зориулагдсан А, В, С ангиллын гал түймэрийг унтраах чадвартай 2 кг-аас багагүй эзэлхүүнтэй (гал унтраах хүчин чадал дүйх өөр төрлийнх байж болно) хуурай нунтаг гал унтраагуур нэгээс цөөнгүй байна.
- 4.2.8. Дараах нэмэлт хэрэгсэлтэй байна. Үүнд:
- Зөвшөөрөгдөх жин нь 7.5 тонноос дээш тээврийн хэрэгсэлд А, В, С ангиллын гал унтраахад зориулагдсан нийт эзэлхүүн нь 12 кг-аас багагүй хуурай нунтаг төрлийн нэгээс цөөнгүй гал унтраагүй байх бөгөөд нэг гал унтраагуурын эзэлхүүн нь 6 кг-аас багагүй байна.
  - Зөвшөөрөгдөх жин нь 3.5 тонноос их 7.5 тонноос бага тээврийн хэрэгсэлд А, В, С ангиллын гал унтраахад зориулагдсан нийт эзэлхүүн нь 8 кг-аас багагүй хуурай нунтаг төрлийн нэгээс цөөнгүй гал унтраагууртай байх бөгөөд нэг гал унтраагуурын эзэлхүүн нь 6 кг-аас багагүй байна.
  - Зөвшөөрөгдөх жин нь 3.5 тонноос хүртэлх тээврийн хэрэгсэлд А, В, С ангиллын гал унтраахад зориулагдсан 4 кг-аас багагүй эзэлхүүнтэй хуурай нунтаг төрлийн нэгээс цөөнгүй гал унтраагууртай байна.
- 4.2.9. Гал унтраах хэрэгсэл нь бүрэн ажиллагаатай байх бөгөөд жолооч болон бусад багийн гишүүд авахад хялбар байрлалд байршуулна.
- 4.2.10. Бүх жин 16 тонноос дээш аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тормосны “ABS” системтэй байна.
- 4.2.11. 1, 6, 7 дугаар ангиллын аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тээвэрлэлтийн явцад байнга тээврийн хэрэгслийн хурд, байршил тогтоох мэдээллийн системээр заавал тоноглогдсон байна.
- 4.2.12. Аюултай ачааны тээвэрлэлтэд шатдаг хийн генераторт (газогенератор) тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- 4.2.13. 1, 2, 3, 4.1, 4.2, 4.3 дүгээр ангиллын аюултай ачааны тээвэрлэлтэд шатдаг хийгээр ажилладаг хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- 4.2.14. Трактор, тракторын чиргүүл болон хагас чиргүүлээр аюултай ачаа тээвэрлэхийг хориглоно.
- 4.2.15. Аюултай ачаа тээвэрлэж буй автомашинд нэгээс илүү чиргүүл, эсхүл хагас чиргүүл холбохыг хориглоно.
- 4.2.16. Аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн бүхээгт болон ачааны хэсэгт шатахуунаар болон шатдаг хийгээр ажилладаг халаалтын хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.
- 4.3. Аюултай ачааг ачих, буулгах тоног төхөөмөржид тавих шаардлага.

- 4.3.1. Аюултай ачааг ачих, буулгах ажилд аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан өргөх, тээвэрлэх тоног төхөөрөмж, машин механизмыг ашиглана.
- 4.3.2. Өргөх тээвэрлэх төхөөрөмж нь техникийн хувьд бүрэн бүтэн, галын аюулгүй байдлын шаардлага болон эрх бүхий хяналтын газраас тогтоосон шаардлагыг хангасан байна.
- 4.3.3. Ачаа өргөх дамарт болон ачаа өргөх краны сумны алслалтыг өөрчлөх төхөөрөмж нь хоёр тоормосоор тоноглогдсон байна. Хэрэв нэг тоормозтой бол дамарт ирэх ачаалал нь түүний тооцоологдсон даацын 75%-иас хэтрэхгүй байна.
- 4.3.4. Аюултай ачаатай тогтмол ажилладаг ачаа өргөх механизмд ашиглагдах цахилгаан хөдөлгүүр нь тэсэрч дэлбэрээх хамгаалагдсан хийцтэй байх шаардлагатай.
- 4.3.5. Аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн урд болон ард талд ADR мэдээллийн пайз (ADR orange plate)-ыг байрлуулна.



Пайзны тайлбар:

- Улбар шар өнгийн пайз нь гэрэл ойлгогчтой, 40 x 30 см-ийн хэмжээтэй байна.
- Хүрээний өргөн, дундуур зураасны өргөн 15 мм байна.
- Пайз галд 15 минут байсан тохиолдолд бэхэлгээнээсээ салахааргүй, уншигдах боломжтой материалаар хийгдсэн байна.
- Пайзны дээд талд эхний тоо “Үндсэн аюул”-ынх, дараагийн 2 тоо нь нэмэлт аюулын таних дугаар. Хэрэв бодис устай холилдоход урвалд ордог бол өмнө нь «Х» үсэг тавигдсан байна.

- Пайзны доод талд НҮБ-ийн дугаар (дөрвөн оронтой) байна.

Тайлбар:

Үндсэн аюулын тооны тайлбар		
Аюулын талаарх эхний тоо	Шинж чанар	Ангилал
2	Даралт, эсхүл химийн урвалын үр дүнд хий үүсдэг	2
3	Шингэн болон хийний шатамхай чанар, эсхүл өөрөө дөл авалцах шингэн	3
4	Хатуу бодисын шатамхай чанар эсхүл өөрөө гал авалцах хатуу бодис	4.1, 4.2, 4.3
5	Исэлдүүлэгч чанар	5.1, 5.2
6	Халдварын хор хөнөөл, эсхүл аюул	6.1, 6.2
7	Цацраг идэвх	7
8	Зэврүүлэх идэвх	8
9	Өөрөө урвалд орох аюул	9

Нэмэлт аюулын тооны тайлбар	
Хоёрдахь болон гуравдахь тоо	Шинж чанар
0	Ямар нэгэн утга илэрхийлэхгүй
2	Хийн ялгаралт
3	Шатах чанар
5	Исэлдүүлэх чанар
6	Хортой чанар
8	Зэврүүлэх чанар
9	Хурдан урвалд орох эсрдэл үүсгэх чанар

4.3.6. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд техникийн шаардлага байгаа талаар доорх маягтын дагуу гэрчилгээ олгоно.

**ЗАРИМ ТӨРЛИЙН АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГЭРЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, ЗАГВАР**

ЗАРИМ ТӨРЛИЙН АЮУЛТАЙ АЧААНЫ ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХИЙГ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗӨВШӨӨРӨЛ			
1. Гэрчилгээний №:	2. Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч:	3. Тээврийн хэрэгслийн арлын дугаар	4. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар

5. Тээвэрлэгчийн нэр, хаяг:	
6. Тээврийн хэрэгслийн тодорхойлолт:	
6. Суурилагдсан цистерн, тээврийн хэрэгслийн мэдээлэл:	
7. Тээврийн хэрэгслийн тэмдэглэл (ADR-ийн 9.1.1.2 дахь заалтын дагуу) EX/II                      EX/III                      FL                      OX                      AT                      MEMU	
8. Ямар ангиллын аюултай ачаа тээвэрлэх талаарх мэдээлэл: 8.1. Цистерний үйлдвэрлэгч: 8.2. Цистерний сери дугаар: 8.3. Үйлдвэрлэсэн он: 8.4. ADR-ийн 4.3.3.1, эсхүл 4.3.4.1 дэх хэсэгт заасан цистерний код: 8.5.	
9. Тусгай тэмдэглэл:	
10. Хүчинтэй хугацаа:	Гэрчилгээ олгосон байгууллагын тэмдэг:
	Огноо:
	Гарын үсэг:
11. Хүчинтэй хугацааг сунгасан тухай тэмдэглэл (ямар хугацаагаар)	Гэрчилгээ олгосон байгууллагын тэмдэг:
	Огноо:
	Гарын үсэг:
12. Хүчинтэй хугацааг сунгасан тухай тэмдэглэл (ямар хугацаагаар)	Гэрчилгээ олгосон байгууллагын тэмдэг:
	Огноо:
	Гарын үсэг:

Жич:

1. Тээврийн хэрэгсэл бүрт тусад нь гэрчилгээ өгнө.
2. Гэрчилгээний хэмжээ нь 210 мм × 297 мм (формат А4) байна. Нүүрэн бол болон ар талуудыг ашиглахыг зөвшөөрнө. Гэрчилгээ нь цагаан өнгөтэй бөгөөд ягаан диагонал зурвастай байх ёстой.
3. Энэхүү гэрчилгээг тээвэрлэлт хийгдэж дууссан, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд олгосон байгууллагад буцаан өгнө.

Тайлбар:

“EX/II” тээврийн хэрэгсэл гэдэг нь:

Тэсэрч дэлбэрэх бодис болон эд зүйлсийг (1-р ангилал) тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл.

“FL” тээврийн хэрэгсэл гэдэг нь

(а) 60°С-ээс өндөргүй гялбааны хэм бүхий шингэнүүдийг (EN 590:2013 + A1:2017 стандартад нийцэх дизель түлшийг, газойлийг болон стандарт EN 590:2013 + A1:2017 дотор заагдсан гялбааны хэм бүхий № НҮБ 1202 зуухны хөнгөн түлшийг эс тооцон) 1 м3 -ээс илүү багтаамжтай суурилуулагдсан цистернүүд эсвэл салгагддаг цистернүүд, аль эсвэл 3 м3-ээс илүү хувийн багтаамжтай чингэлэг-цистернүүд эсвэл зөөврийн цистернүүд дотор зөөвөрлөх зориулалттай тээврийн хэрэгсэл; эсвэл

(б) гал авалцдаг хийнүүдийг 1 м3-ээс илүү багтаамжтай суурилуулагдсан цистернүүд эсвэл салгагддаг цистернүүд, аль эсвэл 3 м3-ээс илүү багтаамжтай чингэлэг-цистернүүд эсвэл зөөврийн цистернүүд дотор зөөвөрлөх зориулалттай тээврийн хэрэгсэл;

(c) гал авалцдаг хийнүүдийг зөөвөрлөх зориулалттай нийт 1 м3 багтаамжтай тээврийн хэрэгсэл-бүрдэл; эсвэл

(d) 60%-иас илүү устөрөгчийн пероксидыг агуулсан устөрөгчийн тогтворжуулсан пероксидыг эсвэл устөрөгчийн пероксидын тогтворжуулсан усан уусмалыг (ангилал 5.1, № НҮБ 2015) 1 м3-ээс илүү багтаамжтай суурилуулагдсан цистернүүд эсвэл салгагддаг цистернүүд, аль эсвэл 3 м3-ээс илүү багтаамжтай чингэлэг-цистернүүд эсвэл зөөврийн цистернүүд дотор зөөвөрлөх зориулалттай тээврийн хэрэгсэл болно.

**“ОХ”** тээврийн хэрэгсэл гэдэг нь

Тогтворжуулсан устөрөгчийн хэт исэл (пероксид) буюу 60%-иас их устөрөгчийн хэт исэл агуулсан тогтворжуулсан устөрөгчийн хэт ислийн усан уусмалыг (5.1 ангилал, НҮБ-ын № 2015) 1 м<sup>3</sup>-ээс дээш багтаамжтай суурин цистерн эсвэл зөөврийн цистернд, эсхүл 3 м<sup>3</sup>-ээс дээш багтаамжтай чингэлэг-цистерн буюу тээвэрлэх цистернд тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл.

**“АТ”** тээврийн хэрэгсэл гэдэг нь:

(a) “ЕХ/III” эсвэл “FL” тээврийн хэрэгслийг эсвэл MEMU-г эс тооцон, аюултай ачаануудыг 1 м3-ээс илүү багтаамжтай суурилуулагдсан цистернүүд эсвэл салгагддаг цистернүүд, аль эсвэл 3 м3-ээс илүү багтаамжтай чингэлэг-цистернүүд, зөөврийн цистернүүд эсвэл **ОЭХЧ** дотор зөөвөрлөх зориулалттай тээврийн хэрэгсэл, эсвэл

(b) FL тээврийн хэрэгслийг эс тооцон, нийт 1 м<sup>3</sup>-ээс илүү багтаамжтай тээврийн хэрэгсэл-бүрдэл болно.

**“MEMU”** -

- 4.4. Аюултай ачааг ачих, буулгах тоног төхөөмөржөд тавих шаардлага.**
- 4.4.1. Аюултай ачааг ачих, буулгах ажилд аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан өргөх, тээвэрлэх тоног төхөөрөмж, машин механизмыг ашиглана.
- 4.4.2. Өргөх тээвэрлэх төхөөрөмж нь техникийн хувьд бүрэн бүтэн, галын аюулгүй байдлын шаардлага болон эрх бүхий хяналтын газраас тогтоосон шаардлагыг хангасан байна.
- 4.4.3. Ачаа өргөх дамар болон ачаа өргөх краны сумны алслалтыг өөрчлөх төхөөрөмж нь хоёр тоормосоор тоноглогдсон байна. Хэрэв нэг тоормостой бол дамарт ирэх ачаалал нь түүний тооцоологдсон даацын 75%-иас хэтрэхгүй байна.
- 4.4.4. Аюултай ачаатай тогтмол ажилладаг ачаа өргөх механизмд ашиглагдах цахилгаан хөдөлгүүр нь тэсэрч дэлбэрээх хамгаалагдсан хийцтэй байх шаардлагатай.

## **7 дугаар зүйл**

### **Аюултай ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нарт тавих шаардлага**

- 7.1. Аюултай ачаа тээвэрлэх аж ахуйн нэгжид тавих шаардлага.
- 7.1.1. Аюултай ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү техникийн зохицуулалт, бусад стандарт, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангаж, мэргэжлийн байгууллагаар тохирлын үнэлгээ хийлгэсэн байна.
- 7.1.2. Тээвэрлэлтээс үүдэн үүсэх эрсдэлийг харгалзан шаардлагатай даатгалд хамрагдана.
- 7.1.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгслээр хангагдсан байна.
- 7.2. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх жолоочид тавих шаардлага.
- 7.2.1. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг 3 жилээс багагүй хугацаанд жолоодсон туршлагатай, батлагдсан хөтөлбөрийн дагуу холбогдох мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, тээвэрлэлт гүйцэтгэх эрхийн гэрчилгээ авсан байна.
- 7.2.2. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх жолоочийн сургалтад дараах агуулга багтсан байна. Үүнд:
- Аюултай ачаа тээвэрлэж буй автомашин болон сав баглаа боодлын тэмдэглэгээ;
  - Аюултай ачаануудын шинж чанар;
  - Осол саатлын үед эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;
  - Ослын үед аюултай бодисыг саармагжуулах, халдваргүйжүүлэх, гал унтраах зэрэг анхан шатны мэдлэг эзэмших;
  - Гарсан осол саатлын талаар холбогдох албан тушаалтанд мэдээлэл зөв өгөх мэдлэг эзэмших.

- 7.2.3. Аюултай ачаа тээвэрлэлтийг байнга гүйцэтгэх жолооч нь эрүүл мэндийн үзлэгт жилд 2-оос цөөнгүй удаа хамрагдах бөгөөд тээвэрлэлт бүрийн өмнө эмчийн ерөнхий үзлэгт хамрагдана.
- 7.2.4. Тээвэрлэлтийн явцад жолоочид дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
- Зогсож байгаад огцом хөдлөх, хурд авах;
  - Зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад зорилгоор огцом тоормослох;
  - Тээврийн хэрэгслийн авцуулах холбоог салгаж болон хөдөлгүүрийг унтрааж хөдөлгөөнд оролцох;
  - Тээврийн хэрэгсэл дотор болон зогсоолд зогсож буй аюултай ачаатай тээврийн хэрэгслээс 50 м-ээс дотогш зайд тамхи татах;
  - Зогсож буй тээврийн хэрэгслээс 200 м-ээс дотогш зайд ил гал түлэх;
  - Ачаатай тээврийн хэрэгслийг хараа хяналтгүйгээр орхих;
  - Батлагдсан тээвэрлэлтийн замналаас хазайх;
  - Тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт зааснаас өөр ачааг аюултай ачаатай цуг тээвэрлэх.
- 7.3. Аюултай ачаа тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтнуудад тавих шаардлага.
- 7.3.1. Ачааг ачиж буулгах, дагалдан явах, хамгаалах гэх мэт ажил үүрэг гүйцэтгэх ажилтнууд аюулгүй ажиллагааны чиглэлээр холбогдох сургалтад хамрагдсан байна.
- 7.3.2. Ачааг хадгалах үүрэг бүхий ажилтнууд нь аюулгүй ажиллагааны тусгай зааварчилгаа, осол саатлын үед аюулын хохирлыг арилгах сургалтад хамрагдсан байна.
- 7.3.3. Ачааг ачих, буулгах механизм дээр ажиллах ажилтан нь тухайн чиглэлээр 2 жилээс багагүй хугацаанд ажилласан туршлагатай байна.
- 7.3.4. Ачааг ачих, буулгах ажилд байнга ажиллах ажилтан нь жил бүр эмнэлгийн үзлэгт хамрагдана.
- 7.3.5. Аюултай ачааг ачиж буулгах үйл ажиллагаа эрхлэгч оператор нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Ачааг ачиж буулгах тоног төхөөрөмжийн техникийн бэлэн байдлыг хангах;
  - Ачиж буулгах ажлыг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу зохион байгуулахад хяналт тавих;
  - Аюултай ачааны таних тэмдэг, тэмдэглэгээг шаардлагын дагуу хийх;

## **8 дугаар зүйл**

### **Тээвэрлэлт**

- 8.1. Аюултай ачааны тээвэрлэлтийг Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан зохих зөвшөөрөлтэй тээвэрлэгч гүйцэтгэнэ.
- 8.2. Аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу байгуулсан тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.
- 8.3. **Аюултай ачааны тээвэрлэлтэд оролцох ажилтнуудыг сургаж, бэлтгэх**
- 8.3.1. Аюултай ачааг дагалдан явах хүмүүсийг сонгох болон тэдгээрт аюулгүй ажиллагааны талаарх зааварчилгаа өгөх үүрэг хариуцлагыг автотээврийн байгууллагын удирдлагууд хүлээнэ.
- 8.3.2. Аюултай ачааны тээвэрлэлтийн үед дагалдан явах албан тушаалтны үүрэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:
- Ачааг илгээх цэгээс хүрэх цэг хүртэл дагалдан явах, ачааны аюулгүй байдлын хамгаалалтыг хангах;
  - Тээврийн хэрэгслийн жолооч болон хамгаалалтын ажилтнуудад зааварчилгаа өгөх;
  - Аюултай ачааг хүлээн авах цэгүүдэд ачааг хүлээн авах, ачааны гаднах үзлэг (савлагаа, тэмдэглэгээ гэх мэт) шалгалтыг хийх;
  - Ачааг ачих, бэхлэх үйл ажиллагаанд хяналт тавих;
  - Тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцох үеийн болон зогсоолд зогсох үеийн аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх;
  - Аюултай ачааг тээвэрлэлтийг эцсийн цэгт хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэх.
- 8.4. **Аюултай ачааг тээвэрлэх тээвэрлэлтийн замналыг төлөвлөх**
- 8.4.1. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээвэрлэлтийн замналыг тухайн ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэх тээвэрлэгч аж ахуйн нэгж төлөвлөж боловсруулна.
- 8.4.2. Сонгосон тээвэрлэлтийн замналыг дараах тохиолдолд цагдаагийн байгууллагатай зөвшилцөнө. Үүнд:
- “Онцгой аюултай ачаа” тээвэрлэх үед;
  - Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх замнал нь замын хүнд нөхцөл (уулархаг, цастай, гулгаатай, үзэгдэх орчин муу гэх)-д хамаарч байгаа бол;
  - Гурав буюу түүнээс дээш тээврийн хэрэгслээр цуваагаар аюултай ачаа тээвэрлэх бол.
- 8.4.3. Аюултай ачаа тээвэрлэх тээврийн замналыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална. Үүнд:
- Аль болох үйлдвэрлэлийн томоохон объетыг дайран өнгөрөхгүй байх;

- Тээвэрлэлтийн замнал нь томоохон суурьшлын бүс, амралт зугаалга, байгалийн болон түүхэн архитектурын дурсгалт газар, онцгой хамгаалалттай газраар дайрахгүй байх;
- Тээвэрлэлтийн замналд тээврийн хэрэгсэл зогсох болон шатахуунаар цэнэглэх цэгийг тодорхой заана.

8.4.4. Тээвэрлэлтийн замналыг цагдаагийн байгууллагатай зөвшилцөх ажлыг тээвэрлэлт хийхээс 10-аас доошгүй хоногийн өмнө хийж гүйцэтгэх бөгөөд ингэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Төлөвлөсөн тээвэрлэлтийн замналын зураг;
- Тээврийн хэрэгслийн техникийн байдалд гаргасан дүгнэлт(АТХУБ-ийн дүгнэлт байхаар тооцох);
- Ачааны талаарх мэдээлэл;
- Онцгой аюултай ачааны хувьд ачаа илгээгч, эсхүл хүлээн авагчаас гаргасан тээвэрлэлтийн тусгай горим, аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэмэлтээр хүргүүлнэ.

8.4.5. Тээвэрлэлтийн замналын хүчинтэй хугацаа нь тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөлд заасантай ижил байх бөгөөд хэрвээ зөвшөөрөлд хугацаа заагаагүй бол зөвшилцсөн тээвэрлэлтийн замналаар 6 сарын турш тээвэрлэлт гүйцэтгэж болно.

8.4.6. Зайлшгүй шаардлагаар тээвэрлэлтийн замналд өөрчлөлт орсон бол тээвэрлэгч нь энэ тухай тухайн тээвэрлэлтийн замналын дагуу цагдаагийн байгууллагуудад мэдэгдэнэ.

8.4.7. Тээвэрлэлтийн замналын нэг хувь нь цагдаагийн байгууллагад, нэг хувь нь тээвэрлэгч байгууллагад, нэг хувь нь ачааг дагалдан явах ажилтанд, хэрэв тийм ажилтан байхгүй бол жолоочид хадгалагдана.

8.4.8. Тээвэрлэлтийн замналыг доорх загвар маягтын дагуу боловсруулна.

#### АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЗАМНАЛЫН МАЯГТЫН ЗАГВАР

<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>  Цагдаагийн байгууллагын холбогдох албан тушаалтан  Гарын үсэг  Огноо	<b>БАТАЛСАН:</b>  Тээвэрлэгч, эсхүл ачаа илгээгч байгууллагын удирдлага  Гарын үсэг  Огноо
<u>Ачааны аюулын талаарх мэдээлэл</u>	
1. Ачааны нэр, төрөл:	2. Таних тэмдэг
2. Ачааны ангилал:	

3.НҮБ-ын жагсаалтад орсон бодисын болон аюулын дугаар:	
4.Нэг тээврийн хэрэгсэлд ачих ачааны хэмжээ, тн	
5.Нийт тээвэрлэлт гүйцэтгэх рейсийн тоо, эсхүл автомашины тоо	
<u>6.Тээвэрлэлт гүйцэтгэх нөхцөлүүд:</u>	
6.1. Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хурд:	
6.2. Зарим хэсэг замын хөдөлгөөний зохицуулалт хийх шаардлагатай эсэх:	
6.3. Хамгаалах машин дагалдан явах шаардлагатай эсэх:	
6.4. Шөнийн цагаар хөдөлгөөн хийхийг зөвшөөрөх эсэх:	
<u>7. Хөдөлгөөний замналын мэдээлэл:</u> <u>(дайран өнгөрөх суурьшлын бүс, гудамж, зорчих авто замын мэдээлэл)</u>	
8. Ачаа илгээгчийн хаяг, түүнтэй холбогдох утасны дугаар	
9. Ачаа хүрэх хаяг болон хүлээн авагчтай холбогдох утасны дугаар	
10. Зогсох зогсоолын мэдээлэл	
11. Тээврийн хэрэгслийг шатахуунаар цэнэглэх цэг	
12. Шаардлагатай тохиолдолд ачааг түр хадгалах боломжтой дундын цэгийн мэдээлэл	
13. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл (нэр, хаяг, холбоо барих утас)	

### **8.5. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авах**

- 8.5.1. Ачаа-тээврийн дагалдах бичиг баримтын иж бүрдэл, үнэн зөв байдлыг ачаа илгээгч, эсхүл хүлээн авагч, тээвэрлэлтийн замын хуудсыг тээвэрлэгч бүрэн хариуцна.
- 8.5.2. Ачаа хүлээн авах, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг холбогдох норм, дүрмийн дагуу гүйцэтгэх бөгөөд аюултай ачааг тээвэрлэхээр хүлээн авах болон ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөхдөө жингээр нь, харин савласан ачааг ачааны нэгж бүрийн тоогоор гүйцэтгэнэ.
- 8.5.3. Жолооч нь ачааны гаднах тэмдэглэгээ, бэхэлгээ, бичиг баримтыг тээвэрлэлт эхлэхээс өмнө шалгаж үзнэ.

8.5.4. Тээвэрлэлтийн явцад жолоочид дараах бичиг барим байна. Үүнд:

- Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх чиглэлээр сургалтанд хамрагдсан тухай гэрчилгээ;
- Аюултай ачаа тээвэрлэлт хийх боломжтой тухай тээврийн хэрэгслийн техникийн дүгнэлт;
- Ачааны талаар тэмдэглсэн замын хуудас;
- Барааны дагалдах бичиг баримт;
- Ачаа тээвэрлэлт гүйцэтгэх гэрээ;
- Ачаа илгээгчийн зааварчилгаа.

#### 8.6. **Ачааг ачих, буулгах үйл ажиллагаа**

8.6.1. Аюултай ачааг тээврийн хэрэгсэл ачих, буулгах үйл ажиллагаанд ачаа илгээгчийн томилсон эрх бүхий этгээд, эсхүл ачааг дагалдан явах ажилтан хяналт тавина.

8.6.2. Аюултай ачааг тээврийн хэрэгсэлд ачих, бэхлэх, буулгах ажил нь ачаа илгээгч (хүлээн авагч)-ийн хүн хүч, тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх бөгөөд хүчтэй доргилт, цохилт өгөхгүй, оч үүсгэдэггүй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглана.

8.6.3. Аюултай ачааг ачих, буулгахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтраасан байх шаардлагатай бөгөөд хэрэв ачаа илгээгч, хүлээн авагчаас гаргасан тусгай зааварчилгаанд заасан бол жолооч нь ачих, буулгах хэсгийн гадна байна. Хэрэв тээврийн хэрэгсэлд суурилагдсан хөдөлгүүр асаалттай үед ажилладаг өргөх, буулгах механизм ашиглах шаардлагатай тохиолдолд энэ заалтыг мөрдөхгүй байж болно.

8.6.4. Аюултай ачааг ачих, буулгах үйл ажиллагааг тусгай бэлтгэсэн талбайд хийх бөгөөд нэг дор нэгээс илүү автомашинд ачих, буулгах ажлыг зэрэг хийхгүй байвал зохино.

8.6.5. Аюултай ачааг ачих, буулгах талбайд гадны хүн байлгахыг хориглоно.

8.6.6. Цаг агаарын дуу цахилгаантай үед гадаа талбайд тэсэрч дэлбэрэх, галын аюултай ачааг ачиж, буулгахыг хориглоно.

8.6.7. Мөстсөн халтиргаатай талбайд аюултай ачааг ачиж, буулгахдаа талбайд элс цацаж, халтиргааг арилгана.

#### 8.7. **Аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцох**

8.7.1. Тээвэрлэлтийн замналыг цагдаагийн байгууллагатай зөвшилцөх шаардлагагүй ачаа тээвэрлэх тохиолдолд тээврийн хэрэгслийн хурдыг Замын хөдөлгөөний дүрэмд заасныг баримтална. Хэрэв тээвэрлэлтийн замналыг цагдаагийн байгууллагатай зөвшилцөх тохиолдолд шаардлагатай бол цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөнд оролцох хурдыг зааж өгнө.

- 8.7.2. Олон тээврийн хэрэгслээр цуваагаар тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд тээврийн хэрэгсэл хоорондын доор дурдсан хэмжээнээс багагүй байна. Үүнд:
- Тэгш замд зай 50 м-ээс багагүй байх;
  - Уулархаг замд өгсөх болон уруудах үед 300 м-ээс багагүй байх;
  - Үзэгдэх орчин муу (цас, бороо, манантай гэх мэт) үед 300 м-ээс багагүй байх бөгөөд үзэгдэх орчих их муу үед онцгой аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.
  - Ачаа илгээгч, эсхүл хүлээн авагчийн зүгээс аюулгүй байдлыг хариуцах ажилтан цувааны эхний автомашинд явах бөгөөд шаардлагатай тохиолдолд цувааны сүүлийн автомашин ачаа илгээгч, эсхүл хүлээн авагчаас томилогдсон хамгаалалтын ажилтан явна.
- 8.7.3. Онцгой аюултай ачаа тээвэрлэх үед суурьшлын бүсэд жолоочийн амрах зогсолт хийхийг хориглох бөгөөд хүн амын бөөгнөрөл, орон сууцны хорооллоос 200 м-ээс багагүй зайд тусгайлан бэлтгэсэн зогсоолд зогсоно.
- 8.7.4. Аюултай ачаа ачсан тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоохдоо зогсоолын тоормосыг заавал ашиглах бөгөөд налуу газарт нэмэлтээр тээврийн хэрэгсэл өнхрөхөөс сэргийлсэн эвүүрийг ашиглана.
- 8.7.5. Аюултай ачаа тээвэрлэх автомашин нь нэг шатахуун цэнэглэлтээр 500 км-ээс багагүй зай туулах чадвартай байх бөгөөд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, дүгнэлтээр шатахууны нэмэлт сав суурилуулан ашиглаж болно. Аюултай ачаа тээвэрлэж буй автомашиныг явуулан шатахуун цэнэглэгчээр цэнэглэх, эсхүл бэлтгэсэн цэгт цэнэглэнэ.
- 8.7.6. Онцгой аюултай ачаа тээвэрлэж буй автомашин нь анхааруулах шар гэрэл дохиогоор тоноглогдсон байх бөгөөд энэ нь замын хөдөлгөөнд давуу эрхтэй оролцох эрх болохгүй. Шаардлагатай тохиолдолд энэ төрлийн тээврийн хэрэгслийг цагдаагийн автомашинаар хөтлөн явж болох бөгөөд Цагдаагийн автомашин хөтлөн явах эсэхийг цагдаагийн байгууллага шийдвэрлэнэ. Онцгой аюултай ачааг цуваагаар тээвэрлэх тохиолдолд цагдаагийн автомашин заавал хөтлөн явна.
- 8.7.7. Онцгой аюултай ачааг 5-аас дээш тооны автомашинаар цувааны зохион байгуулалтаар тээвэрлэх тохиолдолд тухайн ачааг тээвэрлэх боломжтой нөөц нэг автомашин цувааны хойно дагалдан явна.
- 8.8. Хоосон чингэлэг, савны тээвэрлэлт, ариутгал ба засвар үйлчилгээ**
- 8.8.1. Аюултай ачаа тээвэрлэсний дараа цэвэрлэгээ хийгдээгүй хоосон сав баглаа боодлыг тээвэрлэхдээ тухайн аюултай ачааг тээвэрлэхтэй ижил журмаар, энэхүү зохицуулалтад заасны дагуу гүйцэтгэнэ.
- 8.8.2. Хоосон сав баглаа боодлыг тээвэрлэхэд ашиглах бараа-тээврийн дагалдах хуудсанд тухайн саванд өмнө нь ямар аюултай ачаа байсан тухай тэмдэглэгээг улаан өнгөөр хийнэ.
- 8.8.3. Хоосон сав баглаа боодлыг цэвэрлэх ажлыг ачаа илгээгч (ачаа хүлээн авагч) хариуцаж гүйцэтгэнэ.

8.8.4. Сав баглаа боодлыг бүрэн цэвэрлэсний дараа энгийн ачааны адил журмаар тээвэрлэх бөгөөд энэ тохиолдолд ачаа илгээгч (ачаа хүлээн авагч) бараа-тээврийн дагалдах хуудсанд 'Сав цэвэрлэгдсэн' гэсэн тэмдэглэгээг улаан өнгөөр хийнэ.

8.8.5. Аюултай ачаа тээвэрлэхэд ашигладаг нөөцлүүр сав болон чингэлэгт засвар хийх ажлыг хийхийн өмнө тээвэрлэж байсан бодисын (ачааны) агууламж байгаа эсэхийг холбогдох аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

## **8.9. Тээвэрлэлтийн тусгай нөхцөлүүд**

8.9.1. Энэхүү техникийн зохицуулалтын нэгдүгээр хавсралтад зааснаас бусад тохиолдолд олон төрлийн аюултай ачааг нэг тээврийн хэрэгсэлд, эсхүл нэг чингэлэгт тээвэрлэхийг хориглоно.

8.9.2. Хязгаарлагдмал тоо, хэмжээгээр савласан аюултай ачааг тээвэрлэх.

8.9.2.1. Аюултай ачааг хязгаарлагдмал тоо хэмжээгээр сав баглаа боодолтойгоор нэг тээврийн хэрэгсэлд тээвэрлэхдээ дараах шаардлагуудыг мөрдөхгүй байж болно. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл, чингэлэгт мэдээллийн хүснэгт, тэмдэглэгээ байрлуулах;
- Онцгой байдлын үед авах арга хэмжээний бичгэн зааварчилгаа;
- Тээврийн хэрэгслийн бүтэц, тээвэрлэлтэд гаргах;
- Жижиг чингэлгээр тээвэрлэхийг зөвшөөрөөгүйгээс бусад сав баглаа боодолтой ачаа тээвэрлэх, мөн температурын тохируулгаар тогтворжуулдаг бодисыг тээвэрлэхтэй холбоотой заалтууд.

8.9.2.2. Үүний зэрэгцээ, хязгаарлалтаас үл хамааран дараах зүйлстэй холбоотой заалтуудын шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Сав баглаа боодлын тэмдэг, тэмдэглэгээ;
- Тээвэрлэлтийн баримт бичгүүд, тээврийн хэрэгсэлд байх ёстой гал түймрийн эсрэг багаж, хэрэгсэл;
- Сав баглаа боодол, дунд хэмжээний ачааны чингэлэг (IBC), том хэмжээний сав баглаа боодол болон задгай ачааны чингэлгийг үйлдвэрлэх, турших;
- 1 дүгээр ангиллын тэсрэх бодис болон бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах шаардлага.

8.9.2.3. Аюултай ачааг зөвхөн доторх сав баглаа боодолд савлаад, тохирох зориулалтын гадна сав баглаа боодолд давхар хийж тээвэрлэх ёстой. Засварын сав баглаа боодол ашиглаж болно. Аэрозол (Aerosols) буюу шүршигч савтай бодисууд зэрэг НҮБ-ын UN 1950 дугаартай аюултай ачаа, эсхүл бага эзлэхүүн агуулсан хийнд доторх сав баглаа боодол шаардлагагүй. Сав баглаа боодлын бохир жин 30 кг-аас хэтрэхгүй байна.

8.9.2.4. Шил, шаазан болон зарим төрлийн амархан цоордог болон хэврэг материалаар хийгдсэн сав баглаа боодолтой аюултай ачааг тохирсон


засварын сав баглаа боодолд хийнэ. Сав баглаа боодлын бохир жин 20 кг-аас хэтрэхгүй байна.

8.9.2.5. Савлагааны II бүлэгт хамаарах, шил, шаазан эсвэл керамик дотор саванд хийсэн 8-р ангиллын шингэн ачааг хоорондоо зохицох, хатуу завсрын (дунд үеийн) сав баглаа боодолд савлах ёстой.

8.9.2.6. Хязгаарлагдмал тоо хэмжээгээр савласан аюултай ачааг тээвэрлэхтэй холбоотой ADR-ийн чөлөөлөлтүүд нь дараах аюултай ачаанд хамаарахгүй. Үүнд:

- 1 дүгээр ангиллын;
- 3 болон 4.1 (тогворгүй тэсэрх бодис);
- 4.2 дугаар ангиллын;
- 6.2 дугаар ангиллын;
- 7 дугаар ангиллын;
- Хязгаарлагдмал тоо хэмжээгээр (Limited Quantities - LQ) буюу "LQ0" кодтой бусад ангиллын аюултай ачаа.

8.9.2.7. Хязгаарлагдмал тоо хэмжээгээр савлагдсан аюултай ачааны сав баглаа боодолд доор тэмдэглэгээ бүхий шошго наана.



- Хязгаарлагдмал тоо хэмжээний тэмдэглэгээ нь ромбо (алмаз) хэлбэртэй байдаг:
- Хэлбэр: 45 градусын налууутай дөрвөлжин.
- Өнгө: Дээд болон доод өнцөг нь хар өнгөтэй, гол хэсэг нь цагаан эсвэл дэвсгэр өнгөтэйгөө ялгарахаар байна.
- Хэмжээ: Стандарт хэмжээ нь 100 мм х 100 мм байна. Хэрэв сав баглаа боодол хэт жижиг бол 50 мм х 50 мм хүртэл багасгаж болно.
- Хүрээний зураас: Хамгийн багадаа 2 мм зузаантай хар зураасаар хүрээлэгдсэн байна.

8.9.2.8. Хамгийн их жин нь 12 тн-оос дээш жинтэй аюултай ачааг хязгаарлагдмал тоо хэмжээгээр тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн урд болон ард талд энэхүү техникийн зохицуулалтын 8.9.2.7-д заасан тэмдгийг 205 мм х 250 мм хэмжээтэйгээр байрлуулна. Хэрэв тээврийн хэрэгсэл нь энэхүү техникийн зохицуулалтад дурдсан аюултай ачаа тээврийн улбар шар пайзтай тээвэрлэх шаардлагатай бусад төрлийн аюултай ачаа тээвэрлэж

байгаа бол зөвхөн улбар шар пайз ашиглах, эсхүл хоёр пайзыг цуг байрлуулж болно.

- 8.9.2.9. 12 тн-оос дээш жинтэй аюултай ачаа тээвэрлэх чингэлэгт мөн адил 8.9.2.8-д заасан тэмдэг, пайзыг 4 талд нь байрлуулна. Хэрэв уг ачаатай чингэлгийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн урд, хойд талд 8.9.2.8-д заасан тэмдэг, пайзыг байрлуулсан бол чингэлэгт байрлуулахгүй байж болно.
- 8.9.2.10. Хязгаарлагдмал тоо хэмжээгээр савласан аюултай ачаа тээвэрлэж буй аюултай ачааны цэвэр жин нэг тээврийн хэрэгсэлд 8 тн-оос бага бол дээрх тэмдэг, пайзыг байрлуулахгүй байж болно.
- 8.9.2.11. Нэг тээврийн хэрэгсэлд хязгаарлагдмал тоо хэмжээгээр ачиж болох ачааны тоо хэмжээ:

Тээврийн ангилал	Бодис, эсхүл бүтээгдэхүүн Сав баглаа боодлын бүлэг, эсхүл ангиллын код/бүлэг, эсхүл НҮБ-ын дугаар /UN №/	Нэг тээврийн хэрэгсэлд ачих нийт хамгийн их тоо, хэмжээ Кг / л
1	2	3
0	Ангилал 1: 1.1A/1.1L/1.2L/ болон UN № 0190 Ангилал 3: UN № 3343 Ангилал 4.2: Сав баглаа боодлын 1 дүгээр бүлэгт хамаарах бодисууд Ангилал 4.3: UN № 1183, 1242, 1295, 1340, 1390, 1403, 1928, 2813, 2965, 2968, 3129, 3130, 3131, 3134, 3148, 3396, 3398, 3399 Ангилал 5.1: UN № 2426 Ангилал 6.1: UN № 1051, 1600, 1613, 1614, 2312, 3250, 3294 Ангилал 6.2: UN № 2814, 2900 Ангилал 7: UN № 2912-2919, 2977, 2978, 3321-3333 Ангилал 8: UN № 2215 Хайлсан малейны ангидрид Ангилал 9: UN № 2315, 3151, 3152, 3432 болон UN № 2315-д хамаарахаас бусад цэвэрлээгүй сав баглаа боодол.	0
1	Сав баглаа боодлын 1 дүгээр бүлэгт хамаардаг хэдий ч тээврийн тээврийн 0 ангилалд хамаарахгүй бодис, бүтээгдэхүүнүүд болон дараах бодис, бүтээгдэхүүнүүд: Ангилал 1: 1.1B—1.1J a/1.2B-1.2J/1.3C/1.3G/1.3H/1.3J/1.5D a	20

	<p>Ангилал 2: Т, ТС а, ТО, ТФ, ТОС, ТФС бүлгийн бодис</p> <p>Аэрозолууд: С, СО, FC, Т, ТФ, ТОС, ТФС, ТОС</p> <p>Ангилал 4.1: UN № 3225-3230</p> <p>Ангилал 5.2: UN № 3101-3104, 3111-3120</p>	
2	<p>Сав баглаа боодлын 2 дугаар бүлэгт хамаардаг хэдий ч тээврийн тээврийн 0, 1, 4 ангилалд хамаарахгүй бодис, бүтээгдэхүүнүүд болон дараах бодис, бүтээгдэхүүнүүд:</p> <p>Ангилал 1: 1.4B-1.4G, 1.6N</p> <p>Ангилал 2: F бүлэгт хамаардаг</p> <p>Аэрозолууд: F бүлэгт хамаардаг</p> <p>Ангилал 4.1: UN № 3225-3230</p> <p>Ангилал 5.2: UN № 3105-3110</p> <p>Ангилал 6.1: Сав баглаа боодлын 3 дугаар бүлэгт хамаардаг бодисууд</p> <p>Ангилал 9: UN № 3245</p>	333
3	<p>Сав баглаа боодлын 3 дугаар бүлэгт хамаардаг хэдий ч тээврийн тээврийн 0, 2, 4 ангилалд хамаарахгүй бодис, бүтээгдэхүүнүүд болон дараах бодис, бүтээгдэхүүнүүд:</p> <p>Ангилал 2: А болон О бүлгийн</p> <p>Аэрозолууд: А болон О бүлгийн</p> <p>Ангилал 3: UN № 3473</p> <p>Ангилал 4.3: UN № 3476</p> <p>Ангилал 8: UN № 2794, 3795, 2800, 3028, 3477</p> <p>Ангилал 9: UN № 2990, 3072</p>	1000
4	<p>Ангилал 1: 1.4S</p> <p>Ангилал 4.1: UN № 1331, 1345, 1944, 1945, 2254, 2623</p> <p>Ангилал 4.2: UN № 1361, 1362 болон сав баглаа боодлын 3 дугаар бүлгийн бодисууд</p> <p>Ангилал 7: UN № 2908-2911</p> <p>Ангилал 9: UN № 3268 болон тээврийн 0 ангилалд хамаарахгүй аюултай ачаа агуулсан цэвэрлээгүй сав баглаа боодол</p>	Хязгаарлалт байхгүй

8.9.3. Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр савласан аюултай ачааг тээвэрлэх

8.9.3.1. Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр тээвэрлэх ачаа нь дараах гурван түвшний савлагаатай байна. Үүнд:

- **Доторх сав (Inner packaging):** Шингэн зүйлийн хувьд амсар нь гоожихоос хамгаалагдсан, хагарахааргүй материалаар (шил, хуванцар, металл) хийгдсэн байна.
- **завсрын сав (Intermediate packaging):** Дотор сав хагарсан тохиолдолд агуулгыг бүрэн шингээж авах чадвартай зөөлөвч, шингээгч материалтай байна.
- **Гаднах сав (Outer packaging):** Дотор болон дунд савнуудыг механик гэмтлээс хамгаалах хангалттай бат бөх (хатуу хайрцаг гэх мэт) байх ёстой.

8.9.3.2. Чөлөөлөгдөх хэмжээ нь тухайн аюултай ачааны UN дугаар болон "E" кодоос (E0-E5) хамаарна. Үүнд:

- **E0:** Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.
- **E1 - E5:** Код тус бүр дотор болон гадна саванд байх зөвшөөрөгдөх дээд хэмжээг (жишээ нь: 1г/мл-ээс 30г/мл хүртэл дотор саванд) заадаг.

Код	Доторх нэг сав баглаа боодолд савлах хамгийн их хэмжээ (хатуу бодис бол гр-аар, шингэн бодис болон хий бол мл-ээр)	Гаднах нэг сав баглаа боодолд савлах хамгийн их хэмжээ (хатуу бодис бол гр-аар, шингэн бодис болон хий бол мл-ээр)
E0	Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр зөвшөөрөхгүй	
E1	30	1000
E2	30	500
E3	30	300
E4	1	500
E5	1	300

8.9.3.3. Ялгаатай код бүхий аюултай ачааг чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр хамт (нэг дор) савлаж байгаа тохиолдолд гадна савлагаанд байх нийт хэмжээ нь хамгийн өндөр хязгаарлалттай кодоор заасан хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой.

8.9.3.4. Савлагаанд агуулагдах дээд хэмжээ нь "E" кодоос хамаарч дараах хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнд:

- Дотор савны дээд хэмжээ: Бодисоос хамаарч 1 г/мл-ээс 30 г/мл байна.
- Гадна савны нийт хэмжээ: Бодисоос хамаарч 300 г/мл-ээс 1000 г/мл (1 литр) байна.


8.9.3.5. Аюултай ачааг чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр тээвэрлэх сав баглаа боодол нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Доторх сав заавал байх ёстой ба тэдгээрийг хуванцар (хэрэв шингэн аюултай ачаа агуулахад ашиглаж байгаа бол ханын зузаан нь 0.2 мм-ээс багагүй байна), эсвэл шил, шаазан, керамик, шавар эсвэл металаар хийсэн байх ёстой. Мөн дотор савны нэгж бүрийн таг (түгжих төхөөрөмж) нь утсаар (утсан бэхлэгээгээр) найдвартай бэхлэгдсэн байна.
- Дотор савны нэгж бүрийг дунд саванд зөөлөвч (жийргэвч) материалын хамт найдвартай байрлуулах бөгөөд ингэхдээ тээвэрлэлтийн ердийн нөхцөлд сав хагарах, цоорох болон доторх агуулга нь гоожихгүй байхаар тооцож хийнэ.
- Завсрын сав нь дотор сав хагарсан эсвэл доторх бодис нь гоожсон тохиолдолд, ачааны байрлалаас үл хамааран бүх бодисыг өөртөө багтаах боломжтой байх ёстой.
- Шингэн зүйл тээвэрлэх тохиолдолд засварын сав нь доторх савны бүх шингэнийг өөртөө шингээхэд хүрэлцэхүйц хэмжээний шингээгч (абсорбилогч) материалыг агуулсан байх ёстой. Эдгээр шингээгч материал нь тухайн шингэн бодистой ямар нэгэн байдлаар урвалд орохгүй байх шаардлагатай.
- Завсрын савыг бат бөх, хатуу гадна саванд найдвартай байрлуулсан байх ёстой.
- Сав баглаа боодлын төрөл нь олон улсын стандарт шаардлагыг хангасан байх ёстой.
- Сав баглаа боодол нь ачааны аюулын талаарх шошго, тэмдэглэгээ хийх боломжтой хэмжээтэй байна.

8.9.3.6. Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр аюултай ачааг тээвэрлэх сав баглаа боодол нь дараах туршилтуудыг даахуйц бат бөх байна. Үүнд:

- **Уналтын туршилт:** 1.8 метрийн өндрөөс хатуу гадаргуу дээр унахад дотор сав хагарахгүй, гоожихгүй байх.
- **Ороолтын туршилт:** 3 метрийн өндөртэй ижил төрлийн ачааг дээр нь өрөхөд (24 цагийн турш) гадна сав хэлбэрээ алдахгүй байх.

8.9.3.7. Чөлөөлөгдсөн тоо хэмжээгээр тээвэрлэж буй аюултай ачааны гаднах сав баглаа боодолд 100 x 100 мм-ээс багагүй хэмжээтэй тусгай шошго, тэмдэгийг байршуулна.



Жич: \*Шошгон дээр аюултай ачааны үндсэн ангиллын дугаарыг (жишээ нь: 3 эсвэл 8), \*\* илгээгч эсвэл хүлээн авагчийн нэр, хаягийг заавал бичсэн байна. Хэрэв нэг гадна саванд өөр өөр кодын ачааг хамт савласан бол хамгийн өндөр хязгаарлалттай кодын журмыг баримтална.

- 8.9.4. Аюултай ачааг доорх хүснэгийн дагуу бусад энгийн ачаатай цуг тээвэрлэж болно.

#### БУСАД ТӨРЛИЙН БАРААТАЙ ЦУГ ТЭЭВЭРЛЭХЭД ТАВИХ ХЯЗГААРЛАЛТЫН ХҮСНЭГТ

<b>Аюултай ачааны ангилал, дэд ангилал</b>	<b>Аюултай ачаатай цуг тээвэрлэж болохгүй энгийн ачааны нэр төрөл</b>
1	Амархан шатдаг
2.1	Хязгаарлалт байхгүй
2.2	Хүнсний, гоо сайхны, эм-эмнэлгийн хэрэгсэл, гэр ахуйн бараа
2.3	Амархан шатдаг, ургамлын болон амьтны гаралтай тос
3	Амархан шатамхай, хүнсний, гэр ахуйн, норж болохгүй ачаанууд
4.1 4.2	Амархан шатамхай, хүнсний бүтээгдэхүүн
4.3	Амархан шатамха, усны уусмал агуулсан хүнсний бүтээгдэхүүн
5	Амархан шатамхай, ургамлын болон амьтны гаралтай тос, гурил, цардуул, тэжээл болон бусад төрлийн нунтаг ачаа
6	Хүнсний, гоо сайхны, эм-эмнэлгийн хэрэгсэл, гэр ахуйн бараа
7	Бүх ачаа
8	Хүнсний, чулуугаар хийсэн амархан шатамхай эд зүйлс, шил, бааран эдлэл, ширэм, төмөр
9.1	Амархан шатамхай
9.2	Амархан шатамхай, хүнсний бүтээгдэхүүн

#### 8.10. Осол, саатлын үр дагаврыг арилгах

- 8.10.1. Ачаа илгээгч (ачаа хүлээн авагч) нь ослын нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тээвэрлэлт бүрт жолоочид (дагалдан яваа хүнд) гардуулан өгөх бөгөөд осол, саатлын үр дагаврыг арилгах ажилд зориулан ослын багийг томилж, тэдэнд зохих сургалт дадлагын ажлыг зохион байгуулна.
- 8.10.2. Осол, саатлын үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөнд мэдээлэх журам, осол, саатлын баг болон бусад ажилтнуудын хүрэлцэн ирэх, ажиллах дараалал, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж

хэрэгслийн жагсаалт, мөн тэдгээрийг ашиглах технологийн картыг тусгасан байна.

8.10.3. Зам тээврийн осол гарсан тохиолдолд аюултай ачаа тээвэрлэлтийг хариуцаж буй этгээд, жолооч болон харуул хамгаалалтын ажилтнуудын (хэрэв байгаа бол) үйл ажиллагааг удирдан чиглүүлж, цагдаа, онцгой байдлын албанд мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол ослын багийг дуудна.

8.10.4. Ослын газарт ажиллах ослын багийн үүрэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Гэмтсэн сав баглаа боодол болон асгарсан аюултай ачааг илрүүлэх, зайлуулах;
- Гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд жолооч болон тухайн тээвэрлэлтэд оролцож байсан ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Цацрагийг идэвхгүйжүүлэх болон халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хамгаалах хувцас, хэрэгслийг хоргүйжүүлэх, саармагжуулах ажлыг хийх;
- Гарсан осол, саатлын талаар ачаа илгээгч болон хүлээн авагчид мэдээлэл өгөх.

8.10.5. Тээвэрлэлтийн явцад осол, саатал гарсан тохиолдолд ослын баг болон тусгай албаныхныг ирэх хүртэлх анхны үр дагаврыг арилгах ажиллагааг жолооч болон ачааг дагалдан яваа хариуцлагатай этгээд гүйцэтгэх бөгөөд ингэхдээ ачаа илгээгч (ачаа хүлээн авагч)-ээс зааж өгсөн тусгай зааварчилгааны шаардлагыг мөрдөнө.

8.10.6. Ослын үед жолооч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийг бүрэн зогсоож, зогсоолын тоормосыг ажиллуулж, хөдөлгүүрийг унтраах, цахилгаан хүчдэлийг салгах;
- Ослын газарт гадны хүний нэвтрүүлэхгүй байх, тээврийн хэрэгслээс 100 м-ээс багагүй зайд орохыг хориглоно тэмдэг тавих бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх;
- Үүссэн нөхцөл байдлын талаар цагдаа, онцгой байдлын албан мэдэгдэх, хүн гэмтсэн бол эмнэлгийн яаралтай тусламж дуудах;
- Үүссэн осол саатлын талаар ачаа илгээгчид мэдэгдэж, ослын багийг дуудах;
- Ослын газарт ирсэн онцгой байдал, цагдаа, ослын багт аюултай ачааны дагалдах баримт бичгийг үзүүлж, аюулын хор хөнөөлийн талаар мэдээлэл өгөх.

8.10.7. Осол, эсхүл онцгой байдлын үед дараах зааварчилгааг мөрдөнө.

- Тормосны системийг ажиллуулах, хөдөлгүүрийг унтраах, цахилгааныг салгах;

- Гал авалцах (гал гарах) эх үүсвэрээс хол байх, тухайлбал тамхи татахгүй байх, электрон тамхи болон түүнтэй адилтгах төхөөрөмжүүдийг ашиглахгүй байх, мөн ямар нэгэн цахилгаан тоног төхөөрөмж асаахгүй (залгахгүй) байх;
- Зохих онцгой байдлын байгууллагууд, ослын багт гарсан осол, үүссэн нөхцөл байдал, ачааны талаарх аль болох дэлгэрэнгүй мэдээллийг өгөх;
- Ослын хантааз өмсөх, анхааруулах тэмдгийг байрлуулах;
- Тээвэрлэлтийн бичиг баримтыг бэлтгэж, онцгой байдал, ослын багийн бүрэлдэхүүн ирэхэд өгөхөд хялбар газарт тавих;
- Асгарсан бодис, шингэн дээр гишгүй байх, тэдгээртэй харьцах үйлдэл хийхгүй байх, салхины дээд талд зогсож, хий, тоос, утаа, уураар амьсгалахгүй байх;
- Зохистой бөгөөд аюулгүй гэж үзсэн тохиолдолд дугуй, тоормосны систем болон хөдөлгүүрийн хэсэгт гарсан бага хэмжээний буюу эх үүсвэр шатанд байгаа галыг унтраахад гал унтраагуурыг ашиглах;
- Тээвэрлэлт гүйцэтгэж буй багийн гишүүд ачааны хэсэгт гал гарсан тохиолдолд унтраахаар ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх;
- Зохистой бөгөөд аюулгүй гэж үзсэн тохиолдолд усны орчин болон бохир усны систем рүү бодис алдагдахаас сэргийлэх, мөн асгарсан бодисыг тогтоон барих (тархалтыг хязгаарлах) зорилгоор тээврийн хэрэгсэл дээрх тоног төхөөрөмжийг ашиглах;
- Ослын газраас холдох, бусад хүмүүсийг холдохыг анхааруулах, мөн ослын багийн зааварчилгааг мөрдөх;
- Бохирдсон хувцас хэрэгслийг тайлж, аюулгүй байдлаар арилгах.

## **9 дүгээр зүйл**

### **Тээвэрлэлтэд оролцогч байгууллагуудын хүлээх үүрэг**

- 9.1. Ачаа илгээгч болон хүлээн авагчийн хүлээх үүрэг**
- 9.1.1.** Ачааны дагалдах баримт бичгийг бүрдүүлэх;
- 9.1.2. Ачааг холбогдох стандартын дагуу тээвэрлэлтэд бэлдэх, тэмдэг тэмдэглэгээг хийх;
- 9.1.3. Тээврийн хэрэгсэл бүрд ачааг тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг зохих стандарт, дүрэм, журмын дагуу бэлтгэж өгөх;
- 9.1.4. Аюултай ачааг ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- 9.1.5. Ачаа хүлээн авагч нь аюултай ачааг буулгаж дууссаны дараа автомашины тэвш (чингэлэг)-ийг тухайн ачааны үлдэгдлээс цэвэрлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэл (чингэлэг)-д хоргүйжүүлэлт, цацраг идэвхгүйжүүлэлт, халдваргүйжүүлэлт хийх.
- 9.2. Тээвэрлэгч байгууллагын хүлээх үүрэг**

- 9.2.1. Шаардлагатай тээвэрлэлтийн баримт бичгийг бүрдүүлэх, жолооч болон тээвэрлэлт гүйцэтгэх өөрийн байгууллагын бусад ажилтнуудад тээвэрлэлтийн явцад энэхүү зохицуулалтыг дагаж мөрдүүлэх;
- 9.2.2. Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглох, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах, хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангах үүргийг хүлээнэ.

## **10 дугаар зүйл**

### **Боловсон хүчнийг бэлтгэх, түүнд тавигдах шаардлага**

- 10.1. Тээвэрлэгч нь аюултай ачааны тээвэрлэлтийг зөвхөн аюултай ачаа тээвэрлэх чиглэлээр сургалтад хамрагдсан мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлнэ.
- 10.2. Аюултай ачаа тээвэрлэх жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтан (зааварлагч) нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөж эрх олгогдсон байгууллагын тусгайлсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.
- 10.3. Сургалт нь үндсэн, нэмэлт сургалтаас бүрдэнэ.
- 10.4. Аюултай ачаа тээвэрлэх бүх жолооч болон зааварлагч нь үндсэн сургалтад заавал хамрагдана.
- 10.5. Цистернээр эсвэл 1 дүгээр ангилал болон 7 дугаар ангиллын аюултай ачаа тээвэрлэх жолооч, түүнд хяналт тавих, заавар өгөх зааварлагч нь тухайн ангиллын нэмэлт сургалтад хамрагдана.
- 10.6. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллага дор дурдсан агуулгын хүрээнд үндсэн сургалтын хөтөлбөрийг баталж, зохион байгуулна. Үүнд:
- Улс хоорондын болон дотоодын аюултай ачаа тээвэрлэлтийн нөхцөл байдал, олон улсын гэрээ, хэлэлцээрүүд;
  - аюултай ачааны ангилал;
  - аюултай ачааны савалгаа ба шошго;
  - аюултай ачааны тээвэрлэлтийн баримт бичгүүд;
  - тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагатай;
  - тээвэрлэлтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдал;
  - жолоочийн ажил, амралтын горим
  - ачааг аюулгүй ачих, бэхлэх, тээвэрлэх, буулгах аргууд;
  - осол, саатлын үед ажиллах зааварчилгааг дагаж мөрдөх талаар;
  - бусад;
  - дадлага
  - шалгалт
- 10.7. Сургалтын байгууллага нь сургалтад хамрагдсан жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтнуудын талаар мэдээллийн сан хөтөлж, төрийн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана.

**АЮУЛТАЙ АЧААНЫ ЖОЛООЧИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
**ADR DRIVER TRAINING CERTIFICATE**

**MN**


**ЗХ4**  
**ХЭМЖЭЭТЭЙ**  
**ЗУРАГ\***

- 1 (ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААР)\*
- 2 (ӨӨРИЙН НЭР КИРИЛЛ ҮСГЭЭР)\*  
(ӨӨРИЙН НЭР ЛАТИН ҮСГЭЭР)\*
- 3 (ЭЦГИЙН НЭР КИРИЛЛ ҮСГЭЭР)\*  
(ЭЦГИЙН НЭР ЛАТИН ҮСГЭЭР)\*
- 4 (ТӨРСӨН ОГНОО: (ӨӨСС/ЖӨӨЖ))\*
- 5 (ИРГЭНШИЛ)\*
- 6 (ЖОЛООЧИЙН ГАРЫН ҮСЭГ)\*
- 7 (ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГЫН НЭР)\*
- 8 (ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУЧИНТЭЙ ХУГАЦАА: (ӨӨСС/ЖӨӨЖ))\*

---

**ТЭЭВЭРЛЭХ ЭРХТЭЙ АНГИЛАЛ БА НҮБ-ЫН ДУГААР**  
**VALID FOR CLASS(ES) OR UN Nos;**

<p><b>Цистерн</b> TANKS</p> <p>9 (ангиллыг эсвэл НҮБ дугаарыг заах)*</p>	<p><b>Цистернээс бусад</b> OTHER THAN TANKS</p> <p>10 (ангилал эсвэл НҮБ дугаарыг заах)*</p>
--	--



Тээвэрлэлт хариуцсан ажилтан (зааварлагч)-нд олгох гэрчилгээний загвар


**АЮУЛТАЙ АЧААНЫ ЗААВАРЛАГЧИЙН**  
**ГЭРЧИЛГЭЭ**

овогтой                      нь

... оны дүгээр сарын -ны өдрөөс дүгээр сарын ны өдрүүдийн хооронд  
“Аюултай ачааны зааварлагч”-ийн сургалтад хамрагдаж төгссөн тул гэрчилгээ олгов.

**ЗААВАРЛАХ ЭРХИЙН АНГИЛАЛ**

<p><b>Цистерн</b></p> <p>1 2 3 4.1 4.2 4.3 5.1 5.2 6.1 6.2 7 8 9</p>	<p><b>Цистернээс бусад</b></p> <p>1 2 3 4.1 4.2 4.3 5.1 5.2 6.1 6.2 7 8 9</p>
--	---



Хүчинтэй хугацаа:    оны дүгээр сарын -ны өдөр







